



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 05 сарын 29 өдөр

Дугаар 8/21

Чингис хот

Д.Цэцэгсүрэнг ажилд томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1, 44.5, 57 дугаар зүйлийн 57.2, 57.2.2 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйл 23.1, Улсын Их Хурлын 2019 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам”, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”, 2019 оны “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалт батлах тухай” 275 дугаар тогтоолын хавсралт, “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 472 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын хамтарсан 2019 оны 34/31 дугаартай тушаалаар баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам”-ын 1.5, 1.6, 2.1, 5.1-т заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгээ Авлигатай тэмцэх газарт хянуулж, ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал тогтоогдоогүй тул ажлын зайлшгүй шаардлагыг үндэслэн Д.Цэцэгсүрэнг Аймгийн төсвийн ерөнхий нягтлан бодогчийн албан тушаалд оны 06 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн томилсугай.

2. Д.Цэцэгсүрэнгийн үндсэн цалинг ТЗ-6-5 шатлалаар тогтоон 853375 /найман зуун тавин гурван мянга гурван зуун далан таван/ төгрөгөөр, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 15, зэрэг дэвийн нэмэгдлийг 20, Мэргэшсэн нягтлан бодогчийн нэмэгдлийг 15 хувиар тус тус тооцож олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч /Э.Ариунтунгалаг/-д даалгасугай.

3. Аймгийн төсвийн ерөнхий нягтлан бодогчийн албан тушаалын тодорхойлолтод заагдсан чиг үүрэг болон хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Д.Цэцэгсүрэнд үүрэг болгосугай.

4. Д.Цэцэгсүрэнд томилогдсоноос хойш 30 хоногийн дотор хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгээ Төрийн захиргааны удирдлагын хэлтэс /Ж.Гантулга/-т гаргаж өгөх үүрэгтэйг сануулсугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА